



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/210

Мандалговь

“Үндэсний бичиг үсгийн баяр - 2022” үйл
ажиллагааг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60, 66 дугаар зүйлийн 60.1.1, 66.1, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг, Сангийн Сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 08 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний хэл бичиг, түүнтэй холбогдолтой ёс заншил, өв уламжлалыг судлах, сурталчлах, үндэсний бичгээ чадмаг эзэмших, үр хүүхдүүддээ зааж өвлүүлэх, олон түмэнд хүртээлтэй их ажлыг өрнүүлэх зорилго бүхий “Үндэсний бичиг үсгийн баяр - 2022” үйл ажиллагааг зохион байгуулсугай.

2. Үйл ажиллагаанд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3. Үйл ажиллагаанд зарцуулагдах 850,000 (Найман зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100724